

**Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлыг
нөхөн төлөх тухай ГЭРЭЭ
№ХАЗ-2015-/Н01/13**

2015.3.6

Ерөнхий зүйл

Нэг талаас Ашигт малтмалын газар, нөгөө талаас ашигт малтмалын ордыг ашиглах MV-014715 тоот дугаартай 16.84 га талбайтай тусгай зөвшөөрлийг эзэмшигч 5087163 тоот регистр дугаар, 9019019115 тоот гэрчилгээ бүхий "Дүнли" ХХК /цаашид аж ахуйн нэгж гэнэ/ нь Ашигт малтмалын тухай хууль, Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 81 тоот тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дахь Хөөтийн нүүрс, шатах занарын ордын эрэл, эрэл үнэлгээний ажлын зардлыг Улсын төсөвт эргүүлэн нөхөн төлөх нөхцөл, үе шат, төлбөрийн хэмжээ, хулээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэгдүгээр зүйл. Ерөнхий эрэл, эрэл-үнэлгээний ажлын зардлын нийт хэмжээ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дахь Хөөтийн нүүрс-шатах занарын ордод хийсэн zuраглал, эрэл, эрэл үнэлгээний ажилд Улсын төсвөөс нийтдээ 19135045.0 төгрөгийн зардал гарсан /1682, 1949, 3171, 4935 тоот тайлангуудын нийлбэрээр/ бөгөөд MV-014715 тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд ноогдох хэмжээг Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор баталсан журамд заасан аргачлалын дагуу тооцоход 21789774 төгрөг буюу 11016 ам.доллар /арван нэгэн мянга арван зургаан ам.доллар, 00 цент/ болж байгааг хоёр тал зөвшөөрөв.

Хоёрдугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

1. Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд заасан зардлыг 5 жилийн хугацаанд төлөх бөгөөд дор дурьдсан хуваарийн дагуу төлбөр хийх өдрийн төгрөг, америк долларын ханшаар тооцож төгрөгөөр төлнө.

2015 онд	2216 US\$	(хоёр мянга хоёр зуун арван зургаан ам.доллар, 00 цент)
2016 онд	2200 US\$	(хоёр мянга хоёр зуун ам.доллар, 00 цент)
2017 онд	2200 US\$	(хоёр мянга хоёр зуун, 00 цент)
2018 онд	2200 US\$	(хоёр мянга хоёр зуун, 00 цент)
2019 онд	2200 US\$	(хоёр мянга хоёр зуун, 00 цент)

2. Энэхүү гэрээний Хоёрдугаар зүйлийн 2.1-т дурьдсан онд хийхээр хуваарилсан төлбөрийг тухайн оны улирлуудад Хавсралт 1-д заасан байдлаар Ашигт Малтмалын Газрын Төрийн сан банкны төгрөгийн 900000712, Улаанбаатар банкны долларын 2600073394 тоот дансанд хийнэ.

3. Хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр хийсний дараа уг төлбөр Ашигт Малтмалын Газрын дансанд орсон эсэхийг шалгаж болно.

4. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн 2, 3-аар тохиролцсон үүргийн дагуу тухайн улирлын төлбөрөө улиралдаа багтаан хийгээгүй, 4 дүгээр улирлын төлбөрөө тухайн оны 12 дугаар сарын 20-ны дотор хийгээгүй бол Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 7 дахь заалтын дагуу хугацаа хэтэрсэн хоног тутам тухайн улиралд төлбөл зохих төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх торгууль төлнө.

АМГ-НХ-ийг төлөөлж .

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

"Дүнли" ХХК-г төлөөлж .

2015.03.04

**Гуравдугаар зүйл. Ашигт малтмалын газрын
хүлээх үүрэг, эрх**

1. Энэхүү Гэрээний нэгд заасан нөхөн төлбөрийн хэмжээг нөхөн төлбөр хийхээр тохиролцсон хугацаанд өөрийн санаачилгаар өөрчлөхгүй.
2. Нөхөн төлбөр хийсэн хугацааг банкинд гүйлгээ хийсэн өдрөөр тооцно.
3. Нөхөн төлбөр хийсэн баримт бичигтэй танилцан төлбөрийн хэмжээ үнэн зөв эсэхийг магадлахдаа төлбөр хийсэн өдрийн америк доллар ба төгрөгийн Монгол Банкнаас зарласан албан ёсны ханшийг баримтлана.

Дөрөв. Бусад зүйл

1. Ашигт Малтмалын Газар болон аж ахуйн нэгжийн төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.
2. Энэхүү гэрээний Хоёрдугаар зүйлийн 2 дахь заалтын биелэлтийг тухайн оны 12 дугаар сарын 20-ны дотор Ашигт Малтмалын Газар болон аж ахуйн нэгжийн төлөөлөгчид хамтран дүгнэнэ.
3. Гэрээг дөрвөн хувь үйлдсэн бөгөөд нэг хувийг Улсын мэргэжлийн хяналтын газар, хоёр хувийг Ашигт малтмалын газар, нэг хувийг ашигт малтмалын орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч тус тус хадгална. Гэрээний хувиуд нэгэн адил хүчин төгөлдөр байна. Гэрээ нь хавсралтын хамт гурван хуудаснаас бүрдэнэ.
4. Аж ахуйн нэгж нь энэхүү гэрээний заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд Ашигт Малтмалын Газар нь шүүхэд хандаж болох бөгөөд шүүх ажиллагаатай холбогдон гарах зардлыг аж ахуйн нэгж хариуцан төлнө.

Гэрээ байгуулсан:

Ашигт малтмалын газрыг төлөөлж:

НҮҮРСНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

Б.АЛТСУХ

Боловсруулсан:

Үйлдвэрлэл, технологийн тасгийн мэргэжилтэн

.....Л.Гүнжидмаа

Хянасан:

Үйлдвэрлэл, технологийн тасгийн дарга

.....Т.Буянбат

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:

"ДҮНЛИ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

.....О.ТОГООНТӨМӨР

Улаанбаатар хот

АМГ-НХ-ийг төлөөлж

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN
"Дүнли" ХХК-г төлөөлж.....

2015.03.04

2015 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1		108.298	1.000.000 ₮	2017-08-02
2		109.158	1.000.000 ₮	2017-08-17
3		109.298	1.000.000 ₮	2017-08-23
4	2216	100,298	1.000.000 ₮	2017-09-07
		406,618 173.048	1.000.000 ₮ 126.600.000 ₮ Числ - 2216 ₮	2017-09-28 1192,18

2016 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3				
4	2200			

2017 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3				
4	2200			

2018 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3				
4	2200			

2019 онд

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3				
4	2200			

Нүүрсний хэлтэс

Тайлбар тооцоо:

АМГ-НХ-ийг төлөөлж...

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN
 2015.03.04
 "Дүнли" ХХК-т төлөөлж
 ХТУ0902 О 3007163

Тайлбар тооцоо:

Хөөтийн нүүрс-шатах занарын ордын зураглал, эрэл, эрэл үнэлгээний ажилд улсын төсвөөс гарсан зардлын, MV-017480 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамрах нөхөн төлбөрийн хэмжээ

Хөөтийн нүүрс-шатах занарын орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос 300 км, Мандалговь хотоос 130 км зайд оршино.

Газарзүйн солбицол: Өргөрөг $45^{\circ} 46' 00''$ Уртраг $107^{\circ} 43' 00''$

Ордын судалгааны түүх, хайгуулын ажлын танилцуулга:

Хөөтийн нүүрс-шатах занарын ордын орчимд хийгдсэн геологийн судалгааны ажлуудыг Геологийн мэдээллийн төв архивт хадгалагдаж байгаа тайлангуудаас шүүн үзэхэд дараах ажлууд хамрагдаж байна. Үүнд:

Тайлангийн дугаар 1682: В.В.Соловьев, В.И.Ермакова зохиогчтой 1964 онд Дундговь аймгийн Баянжаргалангийн хэсэгт хийсэн нүүрсний эрлийн ажлын тайлан.

Хэтийн төлөв бүхий Хөөтийн хонхор, Өвдөгхудагийн илрэлийг ялгасан ба цаашид эрэл үнэлгээ, хайгуулын ажил хийх шаардлагатай гэж үзсэн байна. ШУТЗ-ийн 1965 оны 06 сарын 07-ны өдрийн дүгнэлтээр Хөөтийн хонхорын нүүрсний ордын нөөцийг C₁ зэргээр 57346.0 мян.тн-оор, C₂ зэргээр 46778.0 мян.тн-оор, нийтдээ 104124.0 мян.тн-оор хүлээн авсан байна.

Тайлангийн дугаар 1949: 1969-1970 онуудад Дундговь аймгийн Баянжаргалан, Говь-Угтаал сумдын нутагт хийсэн 1:200000 масштабтай зураглалын ажлын тайлан.

Тайлангийн дугаар 3171: 1977-1980 онуудад Дундговь аймгийн зүүн хэсэг болох L-48-XXIV, L-49-XIX, XX хавтгайнуудад хийсэн 1:200000 масштабтай металлогений карт зохиох ажлын тайлан.

Тайлангийн дугаар 4935: Л.Мөнхтогоо зохиогчтой 1992-1993 онуудад Хөөтийн нүүрс-шатах занарын ордод хийсэн эрэл-үнэлгээний ажлын тайлан.

ЭХГҮҮҮЯ-ны ШУТЗ-ийн 1996 оны 06 сарын 13-ны 154 тоот дүгнэлтээр эрэл-үнэлгээний ажлын тайланг хүлээн авч, нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар зөвшөөрсөн байна.

Ийнхүү дээрх судалгааны ажлуудыг үндэслэн хийгдсэн ажлын хэмжээ, тухайн компанийн тусгай зөвшөөрлийн талбайд ногдох хэсгийн зургуудыг "Топ сүрвэй" ХХК гүйцэтгэж, "Дүнли" ХХК-ийн захирал О.Тогоонтөмөр танилцсан, баталгаажуулж гаргаж өгсөн зургийг үндэс болгон тусгай зөвшөөрлийн талбайд хамрагдаж буй хэсгийн зардлын нөхөн төлбөрийн гэрээг тус компанийтай гэрээлэхээр дараах байдлаар тооцож байна.

Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолын "Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журмын 2.5-д Ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгосон ордын хайгуулын ажлын нөхөн төлөх зардлын хэсэг болох нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын зардлыг тооцоходоо тухайн ордод хамрагдсан талбайд хийгдсэн эдгээр ажлын зардлын 1 гектарт тооцох зардлын хэмжээг тайланд тусгагдсан зардлыг үндэслэн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн нийт гектараар үржүүлэн тооцох" аргачлалаар тооцон гаргаж байна.

АМГ-НХ-ийг төлөөлж

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN
2014.04.29

"Дүнли" ХХК-г төлөөлж

Үүнд:

1. 1682 тайландаа тусгагдсанаар эрлийн ажлаар Хөөтийн нүүрс-шатах занарын ордын нөөцийг C₁ болон C₂ зэрэг үнэлсэн бөгөөд ойролцоогоор 1287.3 га талбай хамрагдаж, 352800.0 төгрөгний зардал гаргасан байна. Үүнээс 14715A талбайд ямар нэг уулын малталтын ажил хамаарахгүй байaa бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ 16.86 га учир 4620.68 төгрөгний зардал ногдож байна.
2. 1949 тайландаа тусгагдсанаар 1:200000 масштабтай зураглалын ажилд нийт 2918 км² талбай хамрагдаж, 478500.0 төгрөгний зардал гаргасан ба 1 км² талбайд 163.9 төгрөг зарцуулжээ. Үүнээс 14715A талбайд ямар нэг уулын малталтын ажил хамаарахгүй байaa бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ 16.86 га учир 27.6 төгрөгний зардал ногдож байна.
3. 3171 тайландаа тусгагдсанаар ШУТЗ-ийн 1981 оны 05 сарын 27-ны 76 тоот дүгнэлтээр Дундговь аймгийн зүүн хэсэгт хийсэн 1:200000 масштабтай зураглалын ажлын тайландаа 14000 км² талбайд зураглал хийхэд 406700.0 төгрөгний зардал гаргасан ба 1 км² талбайд 29.05 төгрөг зарцуулжээ. Үүнээс 14715A талбайд ямар нэг уулын малталтын ажил хамаарахгүй байaa бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ 16.86 га учир 4.8 төгрөгний зардал ногдож байна.
4. 4935 тайландаа тусгагдсанаар эрэл үнэлгээний ажилд ойролцоогоор 3500 га талбай хамрагдсан бөгөөд 17897045.0 төгрөгний зардал гаргажээ. Үүнээс нэгж т.м өрөмдлөгийн зардал 6000 төгрөг ба 14715A талбайд 33 (49.6 т.м), 35 (23.0 т.м), 59 (15.0 т.м), 61 (15.0 т.м), 69 (22.4 т.м)-р цооногууд хамаарч байна. Мөн дугаарлалтгүй нэг цооног хамаарч байгаа нь тайлангийн шүүлтээс үзэхэд 34 (12.4 т.м)-р цооног байх өндөр магадлалтай тул зардлын тооцоонд хамааруулан тооцсон болно. Нийт 6 цооногийн 137.4 т.м өрөмдлөгийн зардал болон бусад зардлаг эрэл үнэлгээний ажил хийгдсэн нийт талбайг тусгай ашиглалтын зөвшөөрлийн талбайтай жишин тооцох замаар зардлын тооцооллыг хийлжээ.

Дээрх зардлыг 2014 оны тувшинд шинэчлэн дараах байдлаар тооцоолов. Үүнд:

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн ерөнхий түвшин 1991 оноос 2013 оны жилийн эцсийн байдлаар 36493.5 дахин өссөнийг харгалзан үзэж Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолд заасан аргачлалын дагуу зардлыг 2014 оны тувшинд дараах байдлаар тооцлоо.

Үүнд:

$$\begin{aligned} \text{НЭЭҮХААЗ}^{1991} &= 4620.68 + 27.6 + 4.8 = 4653.0 \text{ төг} \\ \text{НЭЭҮХАШЗ}^{1991} &= (\text{НЭЭҮХААЗ} * 0.25 * 2) + (\text{НЭЭҮХААЗ} * 0.75 * 1.75) = 8433.5 \text{ төг}. \\ \text{Үүнийг 2014 оны ET түвшин } 36493.5 \text{ (364.935)} \text{ төгрөг тул:} \\ \text{НЭЭҮХАШЗ}^{2013} &= \text{НЭЭҮХАШЗ}^{1991} * ET^{2013} = 3077702.0 \text{ төг} \Rightarrow 3,416,250,6 \text{ төг} \\ &\quad \Rightarrow 19745.1730,0 \text{ т.м. 8 т.м.} \end{aligned}$$

$$\begin{aligned} \text{НЭЭҮХААЗ}^{1993} &= 834020.0 \text{ төг} \\ \text{Үүнийг 2014 оны ET түвшин } 36493.5 \text{ (364.935)} \text{ төгрөг тул: } ET^{1993} &= 1838.75. \end{aligned}$$

$$\text{НЭЭҮХАШЗ}^{2014} = \frac{\text{НЭЭҮХАШЗ}^{1993}}{ET^{1993}} * ET^{2014} = 16552718.2 \text{ төг}$$

$$3,416,250,6 + 18,373,023,7 = 21,789,274 \text{ төг}$$

$$\text{Нийт: } 3077702.0 \text{ төг} + 16552718.2 \text{ төг} = 19630420.0 \text{ төг}$$

Хөөтийн нүүрс-шатах занарын ордын "Дүнли" ХХК-ийн талбайн хайгуулын ажилд улсын төсвөөс 19630420.0 /арван есөн сая зургаан зуун гучин мянга дөрвөн зуун хоры/ төгрөг зарцуулсан байна.

Тайлбар: -НЭЭҮХААЗ^{1991, 1993} – 1991 болон 1993 оны нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээний ажлын анхны зардал

"Дүнли" ХХК-г төлөөлж

АМГ-НХ-ийг төлөөлж

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

2014.04.29

1838.8

-НЭЭҮХАШЗ^{1991, 1993} - Засгийн газрын 1991 оны 20 дугаар тогтоолын дагуу 1991 оны түвшинд шинэчлэн тогтоосон нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын шинэчилсэн зардал

-НЭЭҮХАШНЗ²⁰¹⁴ - 2014 оны түвшинд нарийвчилсан эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын шинэчилсэн нийт зардал (НЭЭҮХАШНЗ)

-ЕТ²⁰¹⁴ - Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн ерөнхий түвшин 2013 оны эцсийн байдлаар

АМТХуулийн 60 дугаар зүйлийн дагуу 1991 оноос өмнө улсын үйлдвэр, уурхай байгаагүй, олборлолтын ажил явагдаагүй тул хасаж тооцох нөхцөл үүсэхгүй бөгөөд дээрх нөхөн төлбөр төсөвт төвлөрөхөөр байна. Энэхүү мөнгөн дүнг 2014 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хаалтын ханшны байдлаар /1ам.дол=1796.94төг/ ам.долларт шилжүүлбэл 10925.0 ам.доллар болж байна.


Танилцсан:

Б.Алтсүх Нүүрсний Хэлтсийн дарга

Хянасан:

Т.Буянбат НХ-ийн YTTасгийн дарга

Боловсруулсан:

 Б.Улаанхүү YTT-ийн мэргэжилтэн

Зөвшөөрсөн:

“Дүнъли” ХХК-ийн захирал О.Тогоонтөмөр


Жич: Холбогдох баримт бичиг, зургуудыг хавсаргав.

- “Дүнъли” ХХК-ийн MV-014715 талбайд хамаарах улсын төсвийн хөрөнгийн эрэл-хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн гэрээ байгуулах хүсэлт, албан тоот – 1 хуудас
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар – 3 хуудас
- Аж ахуй нэгжийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар – 2 хуудас
- Хөөтийн нүүрс-шатах занарын ордын хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хүлээн авсан тухай АМГ-ын даргын тушаал, ЭБМЗ-ийн дутгэлтийн хуулбар – 7 хуудас
- Ордын паспорт – 6 хуудас
- 1:1000 масштабтай байр зүйн зураглал ба цооног, сувгуудын байрлал тодорхойлсон ажлын тайлан – 11 хуудас
- Ашигт малтмал ашиглах лицензтэй байгууллага, аж ахуйн нэгжийн уурхайн эдэлбэр талбайн хилийг тогтоож шав тэмдэг суулгасан ажлын тайлан – 9 хуудас
- 4935 тайлангийн гаршийн зураг буюу баримт материалын зурагт 14715A ашиглалтын тусгай зөвшөөрлийн хил заагийн буулгаж, хамрагдаж болох цооногуудыг байрлуулсан зураг – 1 хуудас
- Тайлангийн дугаар 4935: “Топсурвэй” ХХК-ийн гүйцэтгэсэн 4935 тайлангаас 14715A талбайд хамрагдаж байгаа уулын малталтын зардлыг тооцоо, цооногийн байршилыг харуулсан зураг, тайлангийн мэдээллийн хуулбар – 5 хуудас
- Тайлангийн дугаар 3171: Тайлангийн хийгдсэн ажлын задаргаа, зардлын хэмжээг харуулсан материалын хуулбар – 4 хуудас
- Тайлангийн дугаар 1949 – Судалгааны талбайн байршилын зураг, хийгдсэн ажлуудын задаргаа, нийт гаргасан зардлын хэмжээний талаар мэдээллийн хуулбар – 3 хуудас
- Тайлангийн дугаар 1682 – Эрлийн ажлын тайлангийн зардлын задаргаа болон хийгдсэн ажлын задаргааны талаар мэдээллийн хуулбар – 1 хуудас

Нийт 53 хуудас материалтай.

АМГ-НХ-ийг төлөөлж

ДАИМЫН ХХК-т төлөөлж

ЭХ СУРВАЛЖ:  M. Togtgerel MN